



ГОВСУМБЭР АЙМГИЙН  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар №05

Сүмбэр сүм


“Ажилтны сургалт, ажиллах нехцэл нийгмийн  
баталгааг хангах” хөтөлбөрийг  
шинэчлэн батлах тухай

Захиргааны ерөнхий тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн “Ажилтны ажиллах нехцэл нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар “Ажилтны сургалтын хөтөлбөр”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж үр дунг тайлагнаж ажиллахыг Хүний нөөц, гадаад харилцааны ажилтан (Д.Мөнгөнжигүүр)-т, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Ерөнхий нягтлан бодогч (Л.Сарангуга) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  
Ш.ОТГОНЖАРГАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
АЖИЛЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН  
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын "Төрийн албаны тухай" хуулийн 55 дугаар зүйл, 55.3. Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасны дагуу тус хуулийн 57 дугаар зүйл, Төрийн албан хаагчийн цалин хөлс, 58 дугаар зүйлд Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр, 60 дугаар зүйлд Төрийн албан хаагчдад олгох тусламж, 61 дүгээр зүйл гэж тус тус заасан байдаг.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежид нийт 83 орон тоотойгоор сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс

Өнөөгийн байдал:

Бүтэц, зохион байгууллалт:

- Нийт 83 ажилтантай 37 эрэгтэй, 46 эмэгтэй.

TY-1-16, TY-2-1, TY-3-4, TY-4-2, TY-5-1, TY-7-4, TY-8-3, TY-9-1, TYMB-1-5, TYMB-2-3, TYMB-3-1, TYMB-4-16, TYMB-5-22, TYMB-6-1, TYMB-7-1 зэргээр цалинжиж байна.

Насны бүлгээр авч үзвэл:

- 25 хүртэлх насны-2,
- 25-29 хүртэлх насны-2,
- 30-34 хүртэлх насны-10,
- 35-39 хүртэлх насны-33,
- 40-44 хүртэлх насны-12,
- 45-49 хүрэлх насны-11,
- 50-54 хүртэлх насны-9,
- 55-59 хүртэлх насны-3,
- 60-64 хүртэлх насны-1;

Боловсролын зэргээр нь авч үзвэл:

- Доктор-0,
- Магситр-28,
- Бакалавр-32,
- Диплом-4,
- Бүрэн дунд-,
- Суурь-1,
- бусад-18:

Багшлах эртэй 37 багш, Зөвлөх-2, тэргүүлэх-7, Заах аргач-28, мастер багш-2, ахлах багш-15, багш-14, дадлагажигч-8.

Ажилласан жил:

➤ Улсад ажилласан жил:

- ✓ анхны жилдээ-6.
- ✓ 1-5 жил-9.
- ✓ 6-10 жил-14.
- ✓ 11-15 жил-37.
- ✓ 16-20 жил-7.
- ✓ 21-25 жил-7.
- ✓ 26 түүнээс дээш жил-3.

➤ Тухайн байгууллагад ажилласан жил:

- ✓ анхны жилдээ-13.
- ✓ 1-5 жил-21.
- ✓ 6-10 жил-17.
- ✓ 11-15 жил-30.
- ✓ 16-20 жил-2.

**ХОЁР ЗОРИЛГО, ЗОРИЛТ-1:**

**Зорилго:** Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар тогтвортой, ажилтандаа эзлтэй төрийн үйлчилгээний албааг төлөвшүүлэх:

**Зорилт:** Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

1. Багш ажилтны цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх.
2. Ажилтны ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх.
3. Багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах.

**ГУРАВ. АРГА ХЭМЖЭЭ**

**1 дүгээр зорилтын хүрээнд:**

1. Багш, ажилтны цалин хөлс, бусад нэмэгдлийг хуульд заасны дагуу олгох
2. Багш ажилтанд олгох хоол, унааны нэмэгдлийг батлагдсан төсвийн дагуу олгох
3. Багш, ажилчдын зэргийг нэмэгдүүлэх
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнтэй уялдуулан шалгуур үзүүлэлтийн дагуу багш, ажилтанд үр чадвар, үр дүнгийн урамшууллыг олгох
5. Багш ажилтны гүйцэтгэлийн үр дүн, амжилтыг үнэлж шагнаж, урамшуулах

**2 дугаар зорилтын хүрээнд:**

1. Багш ажилтны сээтгэл ханамжийн судалгааг жилд 2 удаа авч холбогдох арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх.
2. Багш, ажилтны ажиллах орчин нөхцөлийг сайжруулж засвар, үйлчилгээ хийх, тавилга, эд хогшил, техник, тоног төхөөрөмжөөр хангах
3. Багш ажилтны нэмэлт баталгааг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх, үйл ажиллагаа зохион байгуулах

**3 дугаар зорилтын хүрээнд:**

1. Багш, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээг байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах.
2. Багш ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор тэтгэмж, дэмжлэг, тусламж олгох.

3. Багш ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4. Эрүүл ажлын байрны орчныг бурдуулэх, биесийн тамир, спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх, ажил - амралтын тэнцвэртэй байдлыг хангах.

### ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын төсөв
2. Өөрийн үйл ажиллагааны орлого
3. Бусад

### ТАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Энэхүү хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

### ЗУРГАА. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөө гарган сургуулийн Захирлаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна.
2. Хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан хариуцан ажиллана.
3. Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хагас, бүтэн жилээр төлөвлөгөөний биелэлтийг ханган тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

### ДОЛОО. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		
			2023	2024	2025
<b>Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх</b>					
1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь		Батлагдсан төсвийн дагуу	Батлагдса н төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу
2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл, мянтэг (Хоногт олгохоор тогтоосон дун)		Батлагдсан төсвийн дагуу	Батлагдса нтөсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу
<b>Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бурдуулэх</b>					
1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (багш, ажилтны сэтгэл ханамж)		80 хувиас дээш	80 хувиас дээш	80 хувиас дээш
<b>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх</b>					
2	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) - Төрөлжсөн болон багц		1-ээс дээш	1-ээс дээш	1-ээс дээш

шинжилгээ					
2	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг хамруулсан байдал, хувь	100	90-ээс дээш	90-ээс дээш	90-ээс дээш
3	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал (сая.төг)	Батлагдсан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу

ОХО